

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-19

1.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	4-18
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	18-19
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай/	19

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, Ц.Идэрбат, Л.Мөнхбаясгалан, У.Отгонбаяр, Р.Сэддорж;
Чөлөөтэй: М.Ганхүлэг, С.Лүндэг, З.Мэндсайхан.

Нэг.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхзул, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Д.Батмөнх, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын зөвлөх М.Эрдэнэбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Б.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Т.Аубакир, Ц.Мөнхбат нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Д.Батмөнх нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Замира үг хэлэв.

Б.Бейсен: Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 22 минутад хэлэлцэж дуусав

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд: 15

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Уг асуудлыг 11 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 02 минут үргэлжилж, 24 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 11 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,

ХӨДӨӨ АЖ АХУЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 25 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 54% хувьтай бүрдсэн тул БОХХАА-н байнгын хорооны 25 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. Буланы Бейсен 3 дугаар тойрог ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар 2 дугаар тойрог ирсэн байна, Тилеуханы Аубакир 3 дугаар тойрог ирсэн байна, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог ирсэн байна, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн байна, Пүрэвийн Батчимэг жагсаалтаар ирсэн байна, Сонгобайгийн Замира гишүүн ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна, Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Болдын Уянгаа гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатараас 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах тухай, 3 дугаарт Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсгийн удирдамж батлах тухай. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Санал байхгүй байна.

Нэг.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатар танилцуулна.

О.Амгаланбаатар: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн байна лээ гэдгийг бас эхэнд нь хэлчихье. Улсын Их Хурлын гишүүний хувьд сонгогдсон тойрогтоо очиж ажиллаж байхад малчин ард иргэдийн зүгээс энэ чонотой холбоотой маш олон ийм саналуудыг хэлж байгаа. Хамгийн хүндрэлтэй зүйл нь чоно агнахын тулд заавал сумын төв очоод 5 хоногийн хугацаатай зөвшөөрөл авдаг. Чоно агнах зөвшөөрөл авахдаа яг энэ байрлалаас гэж 1 дүгээрт байрлалыг нь заана, 2 дугаарт гэхээр тэр байрлалыг нь заагаад 5 хоногийн хугацаатай зөвшөөрөл аваад 5 хоногийн хугацаатай яг тэр газраасаа чоно агнаж чадахгүй бол зөвшөөрөл нь хүчингүй болоод, эргээд дахиж сум дээрээсээ очиж зөвшөөрөл авдаг учраас үнэхээрийн энэ хүндрэлтэй боломжгүй байна. Дээр нь болохоор чоно яг тухайн тэр газраа байна

гэж байхгүй ингээд байнгын идэш хоолноосоо болоод ингээд явж байдаг учраас энэ үнэхээр боломжгүй, амьдралд үнэхээр нийцэхгүй байна гэдэг ийм зүйлийг малчид маань маш ихээр ярьж байна.

Тэгээд хуулийн нөхцөл шаардлага яагаад өнөөдөр ингээд үүсээд байгаа юм бэ гэхээр бодит нөхцөл байдал ямар байгаа юм бэ гэхээр Үндсэн хуульд заасан амьд байх, эрүүл байх, эд хөрөнгөө хамгаалах ийм үндсэн эрхтэй. Гэтэл өнөөдөр малчин ард иргэдийн хувьд энэ амьд явах эрх маань үнэхээр зөрчигдөж байна гэж ингэж малчид, иргэд ярьж байна. Нөхцөл байдал яг бодитоороо тийм байна. Яагаад ийм байна вэ гэхээр өнөөдөр энэ сүүлийн энэ жилүүдэд чоно агнах асуудал зогссонтой холбоотой. 1 чоно агнахын тулд 200 хэд билээ, 246 мянган төгрөг төлж байж зөвшөөрөл авдаг. Зөвшөөрөлгүйгээр юм уу эсвэл зөвшөөрөгдсөнөөс өөр газраас чоно агначих юм бол амь нас, эрүүл мэндээ хамгаалаад чоно агначих юм бол нийтдээ 2 сая 260 мянган төгрөгөөр торгож байгаа юм.

Тэгээд хөдөөд ингээд бүх мэдээлэл ил байж байдаг учраас чи эндээс ингээд бас чоно агнасан байна, хот руу чинь дайрсан чоныг агнасан байна гэдэг байдлаар энэ амь насаа хамгаалсан иргэдийг малчдыг сумын хуулийн байгууллагаас цагдаагаас 2 сая 260 мянгаар торгодог. 1 тухайн бүс нутагт гэдэг юм уу чоно элбэгшээд 5, 10, 20-оороо яваад ингээд эхлэхээр хүүхдээ хүртэл ингээд малд явуулж чадахаа больчихсон. Дээр нь болохоор малчдын хувьд энэ бодын төл авч чадахаа больсон. Одоо интернэт орчинд явж байгаа та хэд зарим нь ингээд үзсэн л байх. Нүцгэн гараараа тийм эмэгтэй чоно алсан байна, тийм эмэгтэй ингэж байгаад нөгөө гулуузаараа буюу ганжаараа чоно алсан байна гэдэг ийм мэдээллүүд маш ихээр явж байгаа. Энэ чинь нэг талдаа үнэхээр эмгэнэл байгаад байгаа. Тэр амь нас нь эрсдэлд учирчихсан, амь насаа хамгаалаад чоно алж байгаа баатарлаг зүйл гэж интернэтээр сурталчилж ингэж хүмүүс харж байгаа боловч нөгөө талд нь нөгөө Монгол хүний чинь амь нас эрсдэлд учраад байна гэдэг талыг огт ярихгүй байгаад байгаа юм.

Гэтэл өнөөдөр Улаанбаатар хотод гэдэг юм уу, энэ төв суурин газар айлын хашаан дотор хутга барьсан хүн орж ирээд амь насанд нь заналхийлэхэд аргагүй хамгаалалт гэдэг байдлаар тэр амь насаа хамгаалаад нөгөө талдаа хохирол учруулахад ялаас чөлөөлөгдөх ийм боломжтой. Гэтэл өнөөдөр чоно гэдэг тэр араатан хотонд нь орж ирээд, малыг нь бариад, хүн мал сүргээ хамгаалаад, эд хөрөнгөө хамгаалаад тэр бизнесээ хамгаалаад нөгөө чоныг алах гэдэг юм уу, цааш нь дайжуулах ямар ч боломжгүй болчихсон. Хэрвээ буудаад алчих юм бол нөгөө бууг нь хурааж авч байна. Дээр нь болохоор магадгүй юу унаа тэрэгтэй явж байгаад алчих юм бол унаа тэргийг нь хурааж авч байна. Оролцогч гэж хэлээд тав, зургуулаа явж байвал бүгдийг нь энэ 2 сая 260 мянгаар болдог ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа юм. Тэгэхээр яг малчин ард иргэдийн хувьд амь нас, бизнес болсон мал сүргээ, эд хөрөнгөө хамгаалахын тулд энэ чоныг агнаж болно гэсэн ийм л заалтыг Амьтны тухай хуульд оруулахаар өргөн барьсан байгаа. Та бүгд маань энийг дэмжиж өгөөч гэж хэлэх байна.

Б.Бейсен: Амгаланбаатар гишүүнд баярлалаа.

О.Амгаланбаатар: Заалтыг нь уншаад яачихъя. Тэгээд энэ ер нь ард иргэдэд учирч байгаа энэ аюулын талаарх бичлэг баримтууд байгаа. Тэгээд бас та хэд хүсвэл дэлгэц дээр үзүүлэх боломжтой. Тэгээд Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, нэмэлт оруулах тухай 1 дүгээр зүйл. Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.7 дахь хэсэг нэмсүгэй гээд 25.7. Амь нас, мал

сүргээ хамгаалах зорилгоор чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй гэсэн ийм заалт л нэмж байгаа юм. Тэр нь болохоор ард иргэдийн хувьд амь нас, эрүүл мэнд, мал сүрэг, бизнесээ хамгаалах тэр боломжийг нь нээж өгч байгаа л гэсэн үг.

Б.Бейсен: Амгаланбаатар гишүүнд баярлалаа. БОХХАА-н байнгын хорооны 25 оны 3 сарын 25-ны өдрийн хуралдаанд оролцох ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайд, Даваасамбуугийн Батмөнх Улсын Их Хурлын Ардчилан намын бүлгийн зөвлөх, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Мөнхийн Эрдэнэбилэг Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын зөвлөх гээд энэ ажлын хэсэг танилцуулъя. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуулт асуух гишүүн байна уу? Нэрс өгнө үү? Мөнхбат гишүүнээр тасалъя. Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах танилцуулгыг сонслоо. Агуулгын хувьд дэмжиж байна. Саяхан бас говийн бүс нутгаараа иргэд сонгогчидтойгоо, тэр дундаа малчидтай уулзаад ирсэн. Хэд хэдэн асуудлууд тавьж байгаагийн нэг нь энэ мал сүргээ хамгаалахтай холбоотой, хээрийн зэрлэг амьтан буюу чоно, мөн уулархаг бүс нутагт ирвэс гэдэг амьтан. Энэ амьтдаас мал сүргээ хамгаалах, амь нас, эрүүл мэндээ хамгаалах талаар ярьж байна. Ер нь ганц энэ жил ч биш сүүлийн хэдэн жилүүдэд энэ зэрлэг амьтдын тоо толгой өсөж байгаатай холбогдуулаад мал сүрэг рүү, хүн рүү дайрах үзэгдэл бол жил болгон нэмэгдэж ихсэж байна гэдэг зүйлийг ярьж байна. Тэгэхээр зэрэг саяын танилцуулгатай холбогдуулаад асуухад ер нь Монгол орны хэмжээнд хийсэн ямар судалгаанууд байна вэ? Тухайлбал энэ хэчнээн хэмжээгээр тоо толгой нь өсөж үржиж байна, сүүлийн жилүүдэд тоо толгой нь өсөж байна уу, буурч байна уу? Мөн өмнө нь хохирол авсан мал сүргээ чононд бариулсан иргэд маань нөхөн төлбөр даатгалд мал сүргээ даатгуулах байдал ямар байдаг юм бэ? Эргэж нөхөн төлбөр авах ийм боломж нөхцөл нь хэр байна вэ, энэ талаар хийсэн судалгаа байна уу, үгүй юү? Мөн хууль бусаар хууль зөрчиж чоно агнаж байгаад баригдсан ийм шийтгэгдсэн тоон мэдээ хэр байдаг юм бол гэсэн энэ чиглэлийн судалгаанууд яаман дээр ямар байдаг юм? Үүнийг сонсоод, дараа нь тодруулж асууя гэж бодож байна.

Б.Бейсен: 1 номер хариулъя.

Ц.Уранчимэг: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын газрын дарга Уранчимэг. Гишүүний асуултад хариулъя. Судалгаа ямар байдаг вэ гэхээр Амьтны тухай хуулиараа бүх аймгуудад амьтны ан агнуурын менежментийн төлөвлөгөөг 5 жилээр хийж батлуулдаг. Энэ төлөвлөгөөндөө яг агнах зориулалттай агнах, барих амьтны зориулалттай бүх амьтны нөөцийн судалгаа, байгалийн нөөцийн судалгаа буюу ашиглалтын судалгааг заавал хийсэн байдаг. Тэгэхээр аймаг, орон нутгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаагаар нийт 14 аймаг саарал чонон биологийн нөөцийн судалгааг хийсэн байдаг. Энэ судалгаагаар агнуурын зохион байгуулалтын судалгаагаар саарал чонон Архангай, Булган, Говьсүмбэр, Говь-Алтай, Дундговь, Дархан, Дорнод, Өвөрхангай, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгууд хийж, Байгаль орчны яаманд ирүүлсэн байдаг. Тэгэхээр өнөөдрийн тоогоор 13146 мянган биологийн нөөцтэй гэсэн ийм тоо судалгаа байгаа.

Мөн ан, Амьтны тухай хуулийн 35.1-д зааснаар байгалийн тэнцлийг хамгаалах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх, мал, гэрийн тэжээвэр амьтныг өвчин судлах, иргэн, хуулийн этгээдэд хэрвээ хохирол учруулсан бол учралаас сэргийлэх тоо толгойг зохицуулах гэсэн заалтын дагуу аймгууд ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа аймгийн саналыг үндэслээд тухайн жил нь ахуйн болон агнах барих тоог Байгаль орчны яамнаас олгодог. Сүүлийн байдлаар 2019-өөс 24 оны хооронд 1059 саарал чоныг агнах зориулалтаар тоо хэмжээг баталж аймгуудад хүргүүлсэн боловч яг чоно агнасан тоо нь Монгол Улсын хэмжээнд 153 саарал чоныг агнасан байгаа.

Яг саяын гишүүний асуусан хохиролд тооцож, экологийн цагдаад мэдэгдэж яг сүүлийн байдлаар ямар асуудал үүссэн бэ гэхээр чонын сумын иргэдийн ахуйн зориулалтаар агнах энэ хамтран ан ав хийх зохион байгуулалт хүсэлтийн дагуу Хөвсгөл аймаг 2024 онд тоо толгойг сийрэгжүүлэх 200 чонын агналтыг хийсэн байдаг. Энийг Байгаль орчны яамнаас төлбөрийг нь 100 хувиар чөлөөлөх байдлаар бас зохицуулалтыг хийж ажилласан байгаа. Ингээд чонын тодорхой нөхцөлөөр сая Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тушаалаар аймгуудад чиглэл хүргүүлж ажилласан. Энэ чиглэл хүргүүлсэн гол үндэслэл сая Амгаланбаатар гишүүн тайлбарлалаа. Яг амь насаа хамгаалах, дээрээс нь малын малаа хамгаалах ийм тэнцвэрт байдал алдагдаж байна гэдэг үндэслэлээр зэрлэг амьтан хүн рүү дайрсан, хүн амын хүний амь насанд аюул учруулж нөхцөл байдал үүссэн тохиолдолд Эрүүгийн хуулийн дагуу өөрийн эсхүл бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль ба, хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй зүйлийг гэмт хэрэгт тооцохгүй гэж заасны дагуу аюул учруулснаа бодит байдлаар нотолсон тохиолдолд хэрвээ саарал чоно агнасан бол шийтгэл хүлээлгэхгүй гэсэн заалтын дагуу бид бас аймгууд руу чиглэл өгч ажилласан байгаа. Тэгэхээр экологийн цагдаагаас авсан мэдээллээр Хөвсгөл, Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймгуудад тухайн айлын хоттой чоно руу орсон, тэгээд 13 тохиолдлоор ямар нэгэн байдлаар тийм дайралтад өртсөн гэсэн ийм тоо байгаа.

Б.Бейсен: Хууль санаачлагч Амгаланбаатар гишүүн нэмж хариулъя.

О.Амгаланбаатар: Би хариулчихъя. Энэ бид нарын авсан мэдээгээр энэ танилцуулгаар Монгол Улсад 1986 оноос хойш ийм улсын хэмжээнд чонын талаар нарийвчилсан судалсан судалгаа мэдээлэл байхгүй болно гэсэн ийм танилцуулга ирсэн. 86 оноос хойш нарийвчилсан судалгаа. Харин сая 2023 онд Бямбацогт Ховд аймагтаа тийм нарийвчилсан судалгаа хийлгэсэн юм байна лээ. Бямбацогт ганцхан Ховд аймагт. Тэгэхдээ бас яг энэ нөхцөл байдал үүсээд ингээд хийлгэсэн юм байна лээ гэдгийг хэлье. Тэгээд тэр сая Наранбаатар гишүүний асуусан 1 дүгээрт тийм нарийвчилсан судалгаа байхгүй. Тэгээд энэ чоно, чонотой нийлсэн нохой гээд энэ /видео бичлэг явав/ наадхаа яачих, ийм байдаггүй юм байна лээ гэдгийг хэлье.

Дараа нь болохоор тэр нөхөн олговор олгосон тохиолдол бараг байхгүйтэй адилхан.

3 дугаарт гэхээр энэ дээр нэг зүйлийг хэдүүлээ бас ингээд яахгүй бол 2 зүйл яриад байгаа юм. Говийн зүүн 2 аймагт ингээд чононы тоо толгой ингээд.../минут дуусав/

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя гэж байна.

Н.Наранбаатар: Судалгаа ер нь нарийн тийм судалгаа тоо баримт авч чадсангүй. Ер нь сүүлийн жилүүдэд яг чононд бариулж хүний амь нас хохирсон судалгаа байна уу? Мөн сүүлийн жилээр яг хэчнээн мал бариулчхаад яг чононд бариулчхаад байна вэ гэсэн нэг тоо тодруулаадахъя.

Дээрээс нь нэмээд яамнаас асууя. Ирвэстэй холбоотойгоор ирвэсийг нэгэнт улаан номд орчихсон, агнаж болохгүй учраас хохирлоо яаж барагдуулах вэ? Өнөөгийн хууль, эрх зүйн орчинд малаа бариулсан ирвэст бариулсан ийм тохиолдлууд маш олон байгаа. Тэгэхээр яаж нөхөн төлбөрөө авах юм бэ, яаж барагдуулах юм бэ, ямар гарц гаргалгаа байх ёстой юм бэ нэгэнт устгаж болохгүй бол аль эсвэл устгаж болох юм уу?

Б.Бейсен: Амгаланбаатар гишүүн хариулъя. Чоно яагаад ингэж цөөрсөн бэ гэдэг асуудал дээр нарийвчилсан судалгаа байхгүй юм байна лээ. Гэхдээ 2000 оноос 2012 он хүртэл энэ Хятадын талд чонын үнэ нэг чоно 2 сая төгрөгөөр худалдаж авдаг болсонтой холбоотой энэ хурдан буутай машинтай хүмүүс энэ говийн чоныг бол гэдэг юм уу, тал хээрийн чоныг цөөлсөн юм байна лээ. Гэтэл сүүлийн жилүүдэд энэ, нөгөө талдаа чоныг ингэж нэг ийм омогшил болгож эсвэл нэг чоныг алж нэг ийм хийморио сэргээх гэсэн гэдэг юм уу ийм давлагаа гэж ойлгоод байдаг. Гэтэл нөгөө талдаа энэ чинь зүгээр л бизнес байсан юм байна лээ. Чоно Хятадын талд хил дээр 2 сая төгрөг хүрээд хилээр энэ нь гарах боломжтой бас нуур ингээд хулгайгаар гардаг байсан учраас тухайн үед энэ Монгол Улс даяараа чоно алаад, хилээр гаргаад 2 сая төгрөгөөр зарах ийм давлагаа явсан учраас чононы тоо тухайн цаг хугацаанд маш ийм эрчимтэйгээр буурсан юм байна лээ. Гэтэл сүүлийн жилүүдэд энэ зүйл маань байхгүй.../минут дуусав/

Б.Бейсен: Амгаланбаатар гишүүн гүйцээж хариулъя.

О.Амгаланбаатар: 2 сая төгрөгөөр зарах энэ асуудал байхгүй болсон учраас энэ чонын агнах асуудал ингэж багассанаас болоод үнэхээр чонын тоо толгой хэрээс хэтэрсэн ийм байдалтай байгаад байгаа юм. Сүүлийн жилүүдэд энэ чононд бариулж амь насаа алдсан тохиолдол нэг бүртгэгдсэн байгаа юм. Чононд бариулаад ноцуулсан тохиолдол нэлээн хэд бүртгэгдсэн. Та хэдэд бас энэ бичлэг үзүүлбэл бас энэ бичлэг дээрээс яг энэ уултай газруудын нөхцөл байдлыг бас ингээд харуулъя. /видео бичлэг явав/

Б.Бейсен: Амгаланбаатар гишүүн гүйцээж хариулъя. /видео бичлэг явав/

О.Амгаланбаатар: Сая бас энэ Байгаль орчны яамны хүн хэлж байх шиг байна. Зөвшөөрөл өгчхөж байгаа учраас ингэх шаардлагагүй гэдэг агуулгаар ярьж байх шиг байна. Гэтэл яг одоо саяын тохиолдолд амь нас, эрүүл мэндээ хамгаалахын тулд заавал зөвшөөрөл авдаг. Заавал тэр нэг бүсчилж ийм асуудал оролгүйгээр амь нас, эрүүл мэндээ хамгаалах тэр боломжийг нь нээгээд өгчихье л гэж байгаа юм.

Өнөөдөр яг ингээд нарийвчлаад цааш нь яривал тэр Наранбаатарын ярьдаг ирвэсийн асуудал үнэхээр хүнд болчихсон шүү дээ. Ирвэс айлын гэр дээр ирж хэвтчихээд, доороос нь арга ядаад хутгаар бүлж байж гэрээсээ буулгаад явуулж байгаа тохиолдлууд энэ бүх уултай, энэ модтой аймгуудад байж байгаа шүү дээ. Гэтэл энэ асуудал жилээс жилд даамжраад, магадгүй энэ ирвэсээс болоод хүн барьсны дараа энэ асуудал нэг талдаа яригдах байх. Тэгэхээр өнөөдөр энэ чоно бариад нэг хүн барьчихсан байж байна, бариад амь насыг нь хохироочихсон байж

байна. Дахиад нэлээн олон хүнийг бэртээд гэмтээгээд ингээд ураад ноцчихсон, тэрнээс болоод бараг галзуурч байгаа ийм зүйлүүд баримтаар авагдчихсан байж байна. Гэтэл яг ийм тохиолдол дээр энэ чинь хүний амь нас.../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Тэгээд уул нь бол нэг ийм л харилцаа байгаа юм. Би Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаас яг энэ дээр Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагын хувьд ямар бодолтой байгаа вэ бодлогын түвшинд гэдгийг асуух гэж байгаа юм. Ер нь 2000 оны 5 сарын 12-ны өдөр Ан агнуурын тухай хуулийг хүчингүй болгосон. 2012 оны 5 сарын 17-ны Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар ан агнуурын харилцааг Амьтны тухай хуулиар өнөөдөр зохицуулж явж байгаа. Энэ өөрөө их учир дутагдалтай байгаа юм. Уул нь ингээд нэг улсын хэмжээнд чоныг шууд агнадаг болох нэмэлт, өөрчлөлт оруулж ирэхээс илүүтэйгээр бид хууль, эрх зүйн орчноо нэгэнт Улсын Их Хурлын гишүүд цогцоор нь хараад шийдмээр байгаа байхгүй юу.

Дараагийн удаа ирвэс орж ирэх юм уу жишээлбэл? Тэгээд энэ чинь болохгүй байхгүй юу нэг талдаа. Би Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан хүний хувьд хэлж байгаа шүү. Байгалийн нөөцийн тухай хууль гэж бий. Байгалийн нөөцийн тухай хуулийн 22.1.3 билүү, би буруу санаагүй бол энэ зохистой харилцааг нь шийдээд өгчихсөн шүү дээ. Төлбөрөөс чөлөөлөх нь байгаа, хөнгөлөх нь байгаа, аймаг, сумын удирдлагууд нөөцөө тогтоогоод хүсэлтээ Байгаль орчны яаманд ирүүлээд, тэрнийх нь дагуу Байгаль орчны яам хүсэлтийг нь шийдвэрлэж өгөөд л агнуурын ажиллагаа явж байгаа шүү дээ. Энэ дээр ямарваа нэг саадтай юм байхгүй байхгүй юу. Сая энэ Алтай ТВ-н юм байна л даа. Тэгээд сумын Засаг дарга нь тэнд оччихсон live хийгээд зогсож байхаас илүүтэй урьдчилаад суманд нь хэчнээн хэмжээний чоно тоо толгой өсөлт, үржилт явагдаад байгаа юм. Түүн дээрээ арга хэмжээгээ аваад Байгаль орчны яам руу хүсэлтээ өгөөд, агнуурынхаа зөвшөөрлийг аваад л урьдчилаад л хийж байх ёстой байхгүй юу.

Нөгөө талдаа хотонд ороод ирсэн чоныг буудаж алах бүрэн эрх нь байгаа. Ямар ч асуудалгүй түүн дээр. Түүн дээр ямарваа нэг торгууль, ялын асуудал байхгүй. Түрүүн Байгаль орчны яам хэлж байх шиг байна Эрүүгийн тухай хууль. Эрүүгийн хуулиар энэ чинь шууд үндэслэл болохгүй гээд заачихсан шүү дээ. Шийтгэл хүлээх үндэслэл болохгүй гээд заачихсан Эрүүгийн хуулиар. Бид нэг зүйлээр туйлшруулаад нийтэд нь арга хэмжээ авч, Улсын Их Хурал болохгүй гэдэг би зарчимтай байна миний хувьд. Гэхдээ аймгийн удирдлагууд, сумын удирдлагуудын арчаагүй байдалтай холбоотой асуудал байхгүй юу. Тэр аймаг, сумын удирдлагууд арчаатай байсан бол аль хэзээний тоо толгойгоо хийгээд саяын яриад байгаа Амгаланбаатар гишүүний яриад байгаа судалгаагаа хийгээд, ан агнуурынхаа нөөцийг тодорхойлоод, аймаг, сумдаа орох орлогоо тодорхойлоод, энэ чинь орлого шүү дээ. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар орж байгаа орлого байхгүй юу. Сумандаа орлого төвлөрүүлэх ажлуудаа хийгээд, нөгөө талдаа зохистой харьцаагаа бариад ингээд явах нь чухал байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаас асуух гэж байгаа юм. Ямар бодолтой байгаа юм бэ төрийн захиргааны байгууллагын хувьд?

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр сая хөдөөгөөр явж байгаа нөхцөлд иргэдээс маш олон захидлууд яаманд ирж байгаа. Энэ дээр ямар

асуудал хөндөгдөж байгаа вэ гэхээр чонын тоо толгой сүүлийн үед хэт нэмэгдсэнээс болж хоттой хонь руу дайрч байна, хүн айл өрхийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж байна гээд маш олон гомдлууд ярьж байгаа юм. Гэтэл бид яах вэ бүх хуулиудаараа зохицуулчихсан байдаг. Гэхдээ ард иргэд тэр олон хуулийн зохицуулалтыг 1 дүгээрт мэддэггүй юм байна. 2-т олон ийм зохицуулалтад толгой нь эргэчихдэг юм уу яг л энэ заалтаа л харах гээд байдаг. Тэгэхээр сая Засгийн газраас ямар гишүүдэд үүрэг даалгавар өгсөн бэ гэхээр энэ нэг олон толгой эргүүлсэн баахан дүрэм журмаа боль гэсний дагуу бид энэ чонын ан автай холбоотой дүрэм журмуудыг цуцалсан байгаа.

Энэ ямар учраас цуцалсан юм бэ гэхээр хэдийгээр Эрүүгийн хуульд заачихсан ч гэсэн хүмүүс тэрийг төдийлөн уншиж мэддэггүй яг энэ заалтаа хараад байдаг. 2 дугаарт энэ урьдчилж яг аль суман дээр ямар айл руу дайрна, дайрахгүйг төдийлөн тодорхойлоход амаргүй байгаа. Хэдийгээр орон нутгийн засаг захиргаа сумын дарга энэ дээр урьдчилаад манай сумд тоо толгой их нэмэгдлээ энийг агнаж өгөөч гээд ингээд хэдийгээр гаргадаг ч гэсэн яг тухайн айл өрх рүү ингээд дайраад аюул учруулаад байна гэдэг зүйл маш их яригдаж байгаа. Тийм учраас бид энэ чоныг агнахтай холбоотой тэр нэг баахан тусгай зөвшөөрөл авдаг ийм зүйлүүдийг бүгдийг нь цуцалсан байгаа. Тэгэхээр ард иргэдэд ойлгомжтой болох үүднээс яг ингээд мал сүргээ хамгаалах зорилгоор гээд заачихсан энэ заалтыг би дэмжиж байна. Энэ бол байгаад хүмүүст ард иргэдэд ойлгомжтой тодорхой болоход болохгүй зүйл байхгүй.

Түрүүн бас өөрөө хууль санаачлагч хэллээ. Энэ хууль анх ямар зорилгоор гарсан юм бэ гэхээр нөгөө туйлшруулдаг машинаараа хөөж давхиад талын чоныг бүгдийг нь хядаад, та нар сошиал дээр зургийг нь харж л байсан шүү дээ. Ингээд хэдэн давхарлаад өрөөд тавьчихсан ийм зүйлүүд гарснаас энэ хууль Оюун гишүүний үед орж байсан. Тэгэхээр яг энэ мал, амьтан руу дайрсан тохиолдол гээд ингээд иргэдэд ойлгомжтой болгохгүй бол хөдөө орон нутгаар уулзалт хийхээр л энийг асуудаг. Сая манай гишүүд хөдөө орон нутгаар явахаар л бас энийг нь асуугаад байна гээд л над руу ирдэг. Тэгэхээр ер нь зүгээр энэ ойлгомжтой болгох хэрэгтэй. Би хууль санаачлагчид хэлэхэд ажлын хэсгийн хүрээнд энэ олон толгой эргүүлсэн хууль тогтоомжуудаа бүгдийг нь ойлгомжтой цэгцэлж, давхардалгүй болох шаардлагатай гэж бодож байна. Энэ миний хувь хүн, сайдын хувьд ийм бодолтой байна. Мэдээж саарал чоныг, чоно өөрөө байгалийн экологийн тэнцвэрийг хадгалж байдаг амьтан. Чоноо бид хэт их устгаад агнаад ингэх юм бол байгалийн тэнцвэр бас алдагддаг. Тийм учраас энэ дээр бүгд ухамсартай яг энэ заалтынхаа дагуу амь насыг нь хамгаалах нь бас чухал байх гэж үзэж байна.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Амгаланбаатар гишүүний 25.7 буюу амь нас, мал сүргээ хамгаалах зорилгоор чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй гэдэг энэ зүйл заалтыг дэмжиж байгаа. Зөвшөөрөлтэй холбоотой асуудал. Манайх яах вэ тэр журамтай холбоотой асуудал дээр юу л байгаа шүү дээ. Журам гэдэг чинь хуулийн хэрэгжилтийг буюу нарийвчилсан харилцааг л тэр хуулийн дагуу зохицуулж байгаа болохоос биш шинэ харилцааг үүсгэдэггүй байхгүй юу. Манай Монгол Улс шинэ харилцааг журмаар зохицуулаад байгаа учраас л хуулиас давсан журмуудын асуудлыг Засгийн газар дээр цэгцэлж байгаа гэж би ойлгож байгаа юм. 2022 оны 6 сарын 17-ны дотор Зөвшөөрлийн тухай хууль батлагдаж байсан юм. Энэ хуулиар Байгаль орчны яам бүх зөвшөөрлүүдийг аймаг руу шилжүүлж байсан. Энэ хуулиар бид тэр зохицуулах харилцааг ингэж оруулж өгсөн. Зөвшөөрлийн тухай

хууль дээр ямар дагасан харилцаа дээр өөрчлөлт орох уу гэдгийг би Амгаланбаатар гишүүнээс асуух гэж байгаа юм.

Б.Бейсен: Амгаланбаатар гишүүн хариулъя.

О.Амгаланбаатар: Зөвшөөрлийн тухай хууль дээр ямар нэгэн өөрчлөлт орохгүй. Гэхдээ бид энэ юу яаж байгаа энэ дээр бас яах вэ аймагт, аймгийн дарга, аймгийн иргэдийн Хурлын дарга, аймгийн, дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгчөөр ажиллаж байсан энэ Их Хуралд байгаа Их Хурлын гишүүн 20 гаруй хүмүүс бид уулзаад энэ сүүлийн 20, 30 жилд ерөөсөө энэ төвлөрсөн эрх мэдэл гэдэг чинь ерөөсөө энэ хөдөө орон нутгийн хөгжлийн түгжээ болоод байгаа юм байна. Бүх томилгоо, саяын энэ журмын, дахиад санхүүгийн бүх эрх мэдлийг ингээд зөвхөн Улаанбаатар хот руу төвлөрүүлснээс болоод энэ хөдөө орон нутаг эзгүйрэх, хөдөө орон нутагт хөгжил ирдэггүй ийм учраас энийг иж бүрнээр нь өөрчлөхийн тулд энэ Нэгжийн хуульд өөрчлөлт оруулах юм байна, энэ салбар хуулиудад өөрчлөлт оруулах юм байна гээд бид бас ярилцчихсан. Энэ дээр иж бүрэн ийм хуулийн төслийг өргөн барихаар бид ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр тэр хүрээнд саяын хэлээд байгаа журмуудын асуудал, санхүүгийн асуудал, томилгоо.../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Амьтны тухай хуулийн 25.5 дээр Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.23, 1.24, 8.2 дугаар зүйлийн 1.12-т заасан зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд энэ хуулийн 26.2, 26.3-д заасан агнуурын амьтны тоо хэмжээнд багтаан харьяалах нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгож болно гэдэг ийм заалтыг 23 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан хэлбэр байгаа байхгүй юу. Тэгээд энийг би та хэддээ зөрчилдөх вий дээ л гэж асуугаад байгаа юм тодруулж хэлэхэд.

Б.Бейсен: Амгаланбаатар гишүүн хариулъя.

О.Амгаланбаатар: Энэ бас их юу юм байна лээ. Агнах гэдэг үг чинь яг ингээд Монгол үгээр үзвэл ан агнах гэдэг чинь байна шүү дээ зохион байгуулалттай ажил болчихоод байгаа байхгүй юу. Энийг уг нь алах гэж оруулмаар юм байна лээ. Гэтэл чинь энэ хууль дээр чинь тийм үг болохгүй гэдгээрээ агнах гэдгээр яваад байгаа. Тэгэхээр агнах гэдэг асуудлыг ингээд яг ингээд үзвэл ан агная гэдэг чинь зохион байгуулалттайгаар 5, 10-уулаа яагаад ингээд явдаг ийм ажлыг чинь л бид ан агнах гэж яриад байгаа шүү дээ. Гэтэл нөгөө талдаа энэ чинь зохион байгуулалттай биш, амь нас, мал сүргээ хамгаалах зорилгоор энэ бол нөгөө хамгаалалтын арга хэмжээ байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хоёрыг ингээд нэг яг одоо энэ дээр протоколд тэмдэглээд явчихсан нь дээр байх ийм л юм байна лээ. Тэгэхээр зохицуулалтын хувьд яг энэ чинь нөгөө яг л энэ, сая Баянзүрх дүүрэгт юу болов байшин шатахад жишээлбэл тэр хүмүүст нөхөн олговор олгоод ингээд л бөөн асуудал болж байна шүү дээ. Гэтэл малчдын хувьд ямар ч ийм хамгаалалт байхгүй, ямар ч асуудал байхгүй, зөнд нь ингээд хаячихсан байгаад байгаа юм.

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгээд Амгаланбаатар гишүүнээс өргөн барьсан энэ Ан агнуурын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаа юм. Дэмжье. Тэгээд хэлэлцүүлгийн түвшинд тал талаас нь ярьж, энэ хууль

хоорондын нийцэл юмнуудаа хангах барих юмнуудаа анхаарна байлгүй дээ. Би тэгж бодоод байна. Үгүй ээ яах вэ энэ бол үндсэндээ амьдралаас урган гарч ирж байгаа юм. Бид хэдийн өөрийн амьдралын хэв маяг гэдэг юм уу, уламжлалт аж ахуй маань өөрөө байгальтайгаа ойрхон ийм аж ахуй байгаад байдаг. Тийм учраас энэ зэрлэг ан амьтад уламжлалт аж ахуйтай нь тэр лүү нь халдсан гэдэг юм уу албан ёсны хэллэгээр нь яривал ийм үйл явц дээр яах юм бэ гэдэг асуудал. Бусад хуулиудад байгаа л юм байна шүү дээ уг нь бол энэ заалт нь. Тэгээд хууль хоорондын нийцлийг нь хангаад, энэ хууль дээр энэ заалтыг нь авах нь би зохистой юм болов уу гэж ингэж бодож байна гэж нэг.

Агнуур зүй зохион байгуулалтыг улсын хэмжээнд хийж нэг тоо мэдээ гарна. Гэхдээ бүс нутгаараа нарийсгаж гарах ёстой. Тэгж байж сая тэнд хаана нь сийрэгжилт гэдэг юм уу, юм хийх ёстой юм, хаана нь нутагшуулалт хийх ёстой юм гэдэг юм өөрөө гарч ирдэг ийм зүйл бид том тоон дээр эргэлдээд байж боломгүй л дээ. Тийм учраас энэ талаасаа асуудалдаа нэлээн нухацтай хандах, тэр орон нутгууд энэ чиглэлээрх бүрэн эрхээ хэрэгжүүлэх энэ л үйл явц юм байна гэдэг асуудал байгаад байгаа юм ерөөсөө. Тийм учраас энэ талаас нь бүх зүйлийг харах ёстой. Улсын хэмжээнд 14 орчим мянган тоо толгой байгаад байгаа юм уу гэсэн тийм агнуур зүй зохион байгуулалт дээрээ тулгуурлаж гарч ирж байгаа тоо байлгүй дээ. Би яаж ч бодсон тэгж бодож байна. Тэр нь аль бүс нутагтаа ямархуу байгаад байгаа юм гэдэг зүйлээ л их нарийн харж, түүн дээрээ тулгуурлаж бид энэ зохицуулалтын арга хэмжээнүүдээ авах ёстой.

Тусгай зөвшөөрлөөр агнагддаг үнэ цэнтэй агнуурууд байгаад байдаг. Тэрийг дагуулж дагавар ан гэдэг билүү дээ, үүнийг бид бас өгдөг. Тийм учраас тэр ахиу байгаад байгаа бүс нутгуудад дагавар анд нь энэ тоо толгойг бууруулах үүднээс арай ахиу өгөх бодлого тэгж байж наадах чинь өөрөө энэ нөөц чинь өөрөө бодит эдийн засаг болж орж ирэх тухай л ойлголт шүү дээ. Тэгэхээр энэ талаасаа асуудалдаа илүүтэй хандах л ёстой болов уу. Байгаль орчны яам маань энэ талын юмаа хэр боддог юм бэ? Энэ чинь манай Алтай бүс нутаг чинь бас аргаль, угалз, янгирын агнуурын нэлээн том.../минут дуусав/

Б.Бейсен: 1 номер хариулъя.

Ц.Уранчимэг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Яг таны саяын хэлдэг санаа маш чухал. Бид нөгөө Монгол Улсын хэмжээнд гэж харахаасаа илүү бүс нутгаар нь яг тоо толгойг нь зохицуулах, ялангуяа хангайн бүс, тал хээрийн саарал чононы тоо одоогийн тодорхой аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгаснаар тоо толгой цөөрсөн гэдэг ийм тоон үзүүлэлттэй яваа. Хангайн бүс дээр яг агнах зохион байгуулалт нь хийсэн ч гэсэн нөгөө маш бартаат зам туулж асуудал их байдаг учраас агнах ийм асуудал нь ховор, агнагдах байдал нь ховор байдаг. Тэгэхээр яг саяын Батжаргал гишүүний асуусан нөгөө тусгай зориулалтын ангаар орж ирж байгаа тоон дээр давхар ахуйн зориулалтаар агнах амьтны тоо хэмжээ тухайн аймгийн агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөндөө үндэслээд аймаг өөрөө яаманд санал ирүүлээд, тэр тоог нь бүс нутгаар нь баталж өгөхөөр тухайн аймаг, орон нутагтаа зохион байгуулалтаа хийгээд зөвшөөрлөө олгодог ийм харилцаа бол одоо байгаа. Тэгэхээр аймгууд саарал чоныг ер нь хангайн бүсийн аймгууд л агнах зөвшөөрөл хүссэн хүсэлт орж ирдэг. Хүсэлтээ яг жишээ жишээлбэл 2024 онд 411 саарал чоныг агнах хүсэлт 17 аймгаас, 8 аймгаас ирсэн бол энэ нь зөвхөн агнасан тоо нь ерөөсөө 20 хэд гэдэг тоо л орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ нь өөрөө бас нээлттэй байгаа харилцаа.

Б.Бейсен: 6 номер нэмж хариулъя.

Д.Батмөнх: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Батмөнх. Сая гишүүдийн асуусан асуулт болон яамны зүгээс хариулсан хариулттай холбоотойгоор 2 зүйл тодруулж хэлэх гэсэн юм. 1 дүгээрт тэр Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаагаар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22.1.3 дээр энэ нөөц төрөл зүйлийг тогтоох гээд ийм заалт байгаа. Тэгэхдээ энийг 21, 22, 23 онуудад энэ судалгааг аваад үзэхээр нийтдээ 13 аймгийн хэмжээнд ерөөсөө 2-хон аймаг үүнийгээ тогтоосон байж байгаа. Тэгэхээр энэ хуулийн заалт 1 дүгээрт хэрэгжихгүй байна гэсэн үг.

2 дугаарт Амьтны тухай хуулийн 35.1-д байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, тэгээд өвчин халдварлах, иргэн хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно гэсэн заалтыг сая яриад байна л даа. Тэгэхээр энэ заалттай холбоотой өнгөрсөн хугацаанд аймгийн.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя 6 номер.

Д.Батмөнх: Энэ заалттай холбоотой өнгөрсөн хугацаанд аймгуудын мэргэжлийн байгууллагад чонотой холбоотой дээрх нөхцөл тогтоогдож бүртгэгдсэн ийм тохиолдол байхгүй байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр бидний зүгээс нэгэнт энэ юуны тодорхойгүй байгаа, тэгээд хэрэгжихгүй байгаа хуулийн заалтуудыг бас хуулиуд дээр дүн шинжилгээ хийгээд, тэгээд оновчтой байдлаар зохицуулж, иргэдэд ойлгомжтой байдлаар хуулийн зохицуулалт хийж өгөхгүй бол саяын харуулдаг бичлэгээр үзүүлсэн энэ асуудлууд цаашид ч тулгамдана. Тийм болохоор энэ асуудлыг оновчтой байдлаар тийм зохицуулах шаардлагатай байгаа юм.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тэгэхээр нэг ийм зүйл харагдаад байх шиг байдаг юм. Ер нь аливаа юман дээр энэ байгаль өөрийнхөө тэнцвэр тэнцлээ хангаад яваад байдаг л даа. Аливаа амьтны тоо толгой төрөл нэмэгдчихээр зэрэг тэр төрлийн ан амьтдын өвчлөл гэдэг юм уу, асуудал нь нэмэгдчихдэг байхгүй юу. Тэгэхээр зэрэг бид хэд тэр зохистой баланст нь байлгах үүднээс байгаа агнуурын нөөцөө зөв менежментээр авч явах тухай, эдийн засгийн эргэлтэд оруулах тухай л ойлголт. Тэгэхээр үүнийг харин төрийн бодлого барьж байгаа төрийн захиргааны төв байгууллага нь онцгой анхаарал хандуулж, бүс нутгаар нь зөв чиглүүлж л ажиллах ёстой. Үүнийгээ би харин Байгаль орчны яамыг ахиутай хийгээсэй л гэж хараад байна.

Б.Бейсен: Аубакир гишүүн асуулт асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Орж ирж байгаа хуулийг дэмжиж байгаа. Яг тэр бие хамгаалах зорилгоор чоно алсан тохиолдол чинь манай Баян-Өлгий аймагт л болсон л доо. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Улаанхад баг дээр болсон явдал. 1 эмэгтэй нөхрөө хамгаалаад гулуузаар цохиж алсан тохиолдол шүү дээ. Тийм учраас яг энэ хуулийн зохицуулалт шаардлагатай. Гэхдээ энийгээ дагаад чоноо хавтгайгаар нь устгаад байх тохиолдол руу явчих вий. Сая таны ярьсан жишээ жишээлбэл урагшаа гарч байгаа чонын ханш тодорхой хэмжээнд өссөнтэй холбоотой чонын тоо толгой тодорхой хэмжээнд цөөрсөн л дөө. Гэхдээ бид нэг хүн чононд бариулчихсаны дараа амаа бариад суух биш, үгүй ээ би энэ чоныг алчихвал торгуулчихъя шүү, торгуулчихна шүү дээ гэж бодоод нөгөө хүн нь алахгүй байж

байгаад өөрөө алуулчих вий. Тийм учраас энэ орж ирж байгаа нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байна.

Тэгээд Байгаль орчны яамнаас ер нь нэг зохицуулах ёстой зарим зохицуулалтууд байгаад байгаа юм. Жишээлбэл Монгол Улсын хэмжээнд энэ тураг гогой буюу хар галуу бас зохистой түвшинд устгал явуулах хэмжээнд хүртэл шаардлагатай болчихсон байгаа. Зарим нэг аймаг орон нутгаас тарвагыг нүүлгэн шилжүүлэх байдаг юм уу, бусад тарвагагүй газар луугаа нүүлгэн шилжүүлэх харилцаа энэ тэр сүүлийн үед гайгүй яваад байх шиг байгаа юм. Манай Баян-Өлгий аймгийн хувьд тарваганы тоо хэмжээ тэр хамарсан нутаг дэвсгэрийнх нь хэмжээ, дээрээс нь янгир ямаа маш их үржсэн шүү дээ. Аргалын хувьд ч гэсэн 3 жилийн өмнө болсон зудад Баян-Өлгий аймгийн Булган суманд сүрэг сүргээрээ зудад аргал жишээлбэл үрэгдсэн. Энийг мэдээж хэрэг хамгаалах өвс тэжээлээр яах байдаг юм энэ чинь нэг гэрээ контракт энэ тэр хийгээд байдаг байсан, манай Байгаль орчны яамны хүмүүс хэлээд байх шиг байна. Яг энэ өвс тэжээлээр хангах үүрэг энэ тэрийг нь тухайн орон нутаг хариуцаад байдаг юм уу, орон нутаг хариуцах юм бол мөнгө санхүү нь хаанаас гардаг юм гэх зэрэг ингээд зохистой түвшинд аваачих харилцаанууд байгаад байгаа юм.

Яг саяын энэ чононы хувьд яах вэ дээ тэгээд ер нь өмнө нүүдэлчин ард түмэн нэг хотондоо дуу гаргачих хэмжээний энэ нэг буутай ч байх ёстой. Монгол үг байдаг шүү дээ чонотой газар малаа хариул, чулуутай газар гэрээ барь гэж. Тийм учраас малчдадаа энэ хэмжээний сургалтуудаа өгч л байх хэрэгтэй. Малаа устгуулчихсаны дараа фэйсбүүкээр янз бүрийн юмаар ингээд зогсохоосоо илүү энэ чонотойгоо тэмцэж л амьдарч ирсэн шүү дээ ер нүүдэлчин ард түмэн. Тэр ирвэстэйгээ байдаг ч юм уу, баавгайтайгаа байдаг ч юм уу зэрэгцэж амьдраад л тэмцээд л өөрсдийгөө хамгаалах хэмжээнд л байсан. Тийм учраас энэ зэргийн харилцаануудыг манай Хөдөө аж ахуйн байнгын хороо залуу малчдын чуулга уулзалт энэ тэр бас хийдэг. Мал ахуй өөрсдийгөө хамгаалах хэмжээний сургалтууд ч гэсэн ер нь байж байх ёстой юм шиг байгаа юм. Тийм учраас тураг гогой, тарвага, янгирын зохистой түвшинд байлгах дээр манай яам маань ямар бодлоготой байгаа вэ гэдгийг сонсчихъё.

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ түрүүн хууль санаачлагч Амгаланбаатар гишүүн хэлсэн энэ чоно агнасан гэдэг үгэн дээрээ бид хэд бодох ёстой байх. Агнасан гэдэг чинь тусгай бэлдэж яасан, энэ арай өөр хэллэгээр байх ёстой юм уу? Энийгээ хуулийн тэр хэллэгээр нь бусад хуулийн уялдааг хангаарай гэдгийг би хэлсэн. Сая Аубакир гишүүний асуусан асуулт тэр байгалийн тэнцлийг хангах үүднээс энэ бүх тоо толгойг зохицуулах арга хэмжээ авах бүх ийм хуулийн заалтууд нь байгаа. Хар галуун дээр нэг асуудал үүсэж байгаа. Би өөрөө ингээд яг энэ мэргэжлийн хүн биш, мэргэжилтнүүдтэй уулзахаар юу гэж ярьдаг вэ гэхээр үгүй ээ хар галууг устгахгүй. Яагаад гэхээр энэ чинь байгалиараа өөрөө зохицуулдаг юм. Тэгээд ингээд хүчээр устгана гэдэг юм байхгүй гэхээр би юу гэж маргадаг вэ гэхээр үгүй ээ энэ чинь хэтэрхий их болчихоод байна. Тэгээд энэ чинь загасыг бүүр үнэхээр байхгүй болгож байна. Тэр тухайн аймаг нутгийн иргэдээс нь надад маш их гомдол ирээд байна гээд. Энэ дээр бол яг нөгөө мэргэжлийн хүмүүс, мэргэжлийн бус гэдгээр иргэн хүмүүсийн хоорондох нэг ийм ойлголтын зөрөө байдаг.

Сүүлийн үед яах вэ ямар арга бодож олсон бэ гэхээр тэр хар галууг буудаж устгах өөрөө болохгүй гэсэн ийм зүйл ярьж байгаа. Нэг арга байдаг тэр нь бусад

оронд хэт их тоо толгой нэмэгдвэл тэр өндгийг нь нэг ийм нэг бодисоор ингээд бүрдэг, өндгийг нь ингээд будчихдаг будна гэж ярья л даа, бүрхэхээр тэр өндөг хагарахгүй, тэгээд тоо толгой нэмэгдэхгүй ч гэдэг юм уу нэг ийм олон улсын хэрэглэдэг арга байдаг. Тэгэхээр мэргэжилтнүүдийн энэ үг яагаад бид энэ дээр зохицуулалт хийхгүй бол үнэхээр энэ дээр маш том асуудал яриад байгаа. Тарвага болон бусад амьтан их үржсэн газар бид хувийн хэвшлүүдтэй ярьж байгаа, хувийн хэвшлүүд хүсэлт тавиад, бид хамтраад энэ өөр газар нүүлгэн шилжүүлэх дээр тодорхой хувийн хэвшлүүд зардал мөнгийг нь өөрсдөө гаргаад ингээд зохицуулах ийм ажлыг санамж бичгүүд байгуулаад ингээд хамтраад, хийгээд явж байгаа.

Гол нь би Амгаланбаатар гишүүний юуг нь дэмжиж байгаа вэ гэхээр хүнд иргэн хүнд ойлгомжтой л хууль байг, ойлгомжтой. Мэдээж орон нутгийн засаг захиргаа тухайн орон нутагт нь их боллоо гэхэд тэр өөрөө тэр их байна энэ сийрэгжилтийг хийе гэдэг хүсэлтээ өгнө. Гэхдээ яг иргэн Доржийнх руу тэр чоно дайрах, дайрахгүйг тэр Засаг дарга хэлж мэдэхгүй учраас энэ зохицуулалт нь байвал ойлгомжтой юм уу л гэж байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн бусад хуультай уялдуулах тэр Батжаргал гишүүний хэлсэн асуудлыг хууль санаачлагч, манай ажлын хэсгийнхэнтэй хамтраад сайн ажиллах хэрэгтэй гэж хэлэх гэсэн юм. Уранчимэг 1 номер нэмчих.

Б.Бейсен: 1 номер гүйцээж хариулъя.

Ц.Уранчимэг: Гишүүний асуусан тоо баримт нөгөө юутай санхүүжилттэй холбоотой дээр нэмэлт тайлбар өгье. 2024 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар яг саяын нөгөө тусгай зориулалтын ан буюу ахуйн үйлдвэрийн зориулалтаар агнасан амьтнаас олсон орлого нь 14,5 тэрбум төгрөг улсын төсөвт орсон байгаа. Энэ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиараа 50 хувийг буцаагаад яг тухайн амьтныг хамгаалах, зохистой тоо толгойг зохицуулах хамгаалах арга хэмжээнд зарцуулна гэсэн заалттай байдаг. Тэгэхээр өнөөдрийн байдлаар яг 24 онд яг энэ хуулийн хэрэгжилт нь 62 хувьтай гарсан. Гэвч яг амьтан дээр 4,5 тэрбумыг төгрөгийг зарцуулсан байна. Энэ мөнгө нь хаашаа ордог вэ гэхээр тухайн аймгийн орон нутгийн төсөвт ороод тухайн суманд зарцуулах ийм зохицуулалттай байдаг. Тэгэхээр энэ зохицуулалтуудыг хийгээд явах бүрэн боломжтой. Тэгээд тусгай ан дээр тэр хар галуу дээр бид яг шувуу судлаач, загас судлаачтай хамтарсан тооллого хийж яг үржлийн үе нь Монгол Улсад таардаг учраас тухайн.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя 1 номер.

Ц.Уранчимэг: Яг тэр үржлийн үед нь таардаг учраас популяц маш ихээр нөгөө харагдаж байдаг учраас энэ дээр яг сайдын хэлснээр бид бас ийм хамтарсан ийм судалгаа хийгээд, тэгээд зохистой агнах тоо толгойг тэнцүүлэх зохицуулалтыг хийхээр энэ жил төлөвлөсөн байгаа. Тарвага нутагшуулах ажлыг ялангуяа Алтайн тарвагыг нутагшуулах ажлыг Байгаль орчны яам сүүлийн 4 жил маш амжилттай явуулж байгаа. Янгир, ямаа, аргаль дээр яг ан агнуурын менежментийн төлөвлөгөөгөөрөө тухайн байгалийн нөөцөд түшиглэсэн зохистой ашиглалтын нөөцөө тодорхойлоод, тусгай зориулалтын ангийн квотыг Засгийн газраар батлуулаад, тэгээд аймаг нь Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу зохион байгуулалтаа хийгээд явж байгаа.

Б.Бейсен: Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе. Энэ хуулийн үзэл санааг нь дэмжиж байгаа. Манай малчин иргэд өөрсдийнхөө амь нас, эрүүл мэнд, мал сүргээ, эд хөрөнгөө хамгаалах ёстой. Хэд хэдэн хуулиуд байдаг юм байна. Хуулийн уялдаануудын тухай ярьж байна. Ер нь манай хууль өөрөө иргэдэд их тийм ойлгомжтой л байх ёстой л доо. Тийм учраас л энэ заалтыг зайлшгүй шингээж өгөх гэж байгаа юм байна гэж ингэж бодоод байгаа юм. Тэгээд би нэг юм асуух гээд байгаа нь жилдээ 150 гаруй чоно л агнах зөвшөөрөл өгдөг юм уу даа. Миний саяын ойлгосноор ер нь хэд орчим чоно агнаж байвал энэ байгаль экологийн тэнцвэрт байдал нь хадгалагдаад явна гэж үздэг тийм тоо баримт байна уу гэж 1 дүгээрт асуух гэсэн юм.

2 дугаарт нь сая манай Өмнөговь аймгийн Гурвантэс сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчид ирж тойргийн гишүүдтэй уулзалт хийсэн. Хэд хэдэн асуудлуудыг хөндсөн. Энэ дотор нэг чухал асуудал энэ ирвэс яриад байгаа юм. Сая ирвэс нь тэр Наранбаатар гишүүн асуулт асуугаад хариулт авч чадсангүй л дээ. Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт нэмж өгөөч гэж хэлмээр байна. Одоогоор ирвэсийн тоо толгой нь хэр болчихоод байгаа юм бэ? Тэгээд нөгөө энэ чинь бүүр чононоос ч илүү хамгаалалттай тийм юу биз дээ амьтан биз дээ ирвэс. Тэгсэн чинь ялгаа байхгүй тэр Гурвантэс сумын малчид руу ирвэс гурав, дөрвөөрөө мал, малын хот руу нь дайрдаг, тэгээд бас агнаж болдоггүй улаан номд орчихсон, маш өндөр төлбөр хураамжтай, хариуцлагатай бас, бүүр эрүүгийн хариуцлагатай ийм болоод байна энийг яаж зохицуулах вэ гэж ингэж асуулгаад байгаа юм. Тэгэхээр үүн дээр нэг яам маань нэг тодорхой хариулт өгөөч. Тэгээд нэмж тодруулъя араас нь гэж ингэж.

Б.Бейсен: 7 номер Амгаланбаатар гишүүн хариулъя.

О.Амгаланбаатар: Мөнхбат гишүүний асуусан асуултад хариулъя. 1 дүгээрт 1985 оноос хойш нарийвчилсан судалгаа хийгдээгүй учраас энэ яг тэд эд гэдэг юм огт байхгүй юм байна лээ гэдгийг дахиад давтаад хэлчихье.

2 дахь юм нь бол ер нь энэ нийт иргэд дунд гэдэг юм уу энэ яг Одонтуяа сайд өөрөө амьдрал мэддэг учраас зөв яриад байх шиг байна. Түүнээс биш энэ доор нь байгаа мэргэжилтнүүд нэг зааланд суучхаад л нэг том дарга нар юу ч мэдэхгүй. Та бол энэ нэг хэлтсийн дарга нар, энэ газрын дарга нар, мэргэжилтнүүдээ аймгаар яваад тэр ард иргэдтэй уулзуулаад амьдрал үзүүлж сонсгомоор юм байна лээ. Энэ өнөөдөр Их Хурлаас гэдэг юм уу энэ яамнаас чинь амьдралд нийцсэн, энэ амьдралд тулгамдаад байгаа асуудлыг шийдэх хууль, журам, тушаал шийдвэрүүд л гарах ёстой шүү дээ. Гэтэл энд нэг суучхаад нэг шал өөр хөндлөнгийн юм ярьдаг ийм хүмүүсээр энэ яамд дүүрчихсэн байдаг юм байна лээ. Юм ярихаар тэс хөндлөн юм ярьдаг. Тэгээд одоо болохоор нэг юу гэдэг юм нэг юм яриад тэр байгалийн тэнцвэр энэ тэр юм ярихаараа ингээд энэ байгалийн тэнцвэр байх ёстой шүү дээ. Мал, малын тоо ихэссэнээс болоод энэ чоно ингээд малчны хот руу халдаж байгаа шүү дээ гэдэг ийм асуудал ярьдаг.

Гэтэл энэ тоон судалгаа дээр 2000 оноос сүүлийн 25 жилийн энэ малчдын тоон судалгаа байж байгаа юм. Гэтэл 2000 онд Монгол Улс 421 мянган малчинтай байсан бол өнөөдөр 298 мянга болоод ингээд бараг 33 хувиар малчдын тоо бүх аймагт буурчихсан байж байх жишээний 25 жилийн дараа ингээд. Малын тоо өссөн ч гэсэн нөгөө малчдын тоо буурчихаар нөгөө бэлчээрийн тархан буудаллах энэ маань ингээд хумигдчихаж байна гэсэн үг. Тэгэхээр нөгөө бэлчээр юу гэдэг юм нөгөө зэрлэг ан амьтдын тэр нутаг руу нь халдаж ойртоод байна гэдэг асуудал чинь эсрэгээрээ байна гэсэн үг байхгүй юу. 1 малчин чинь нэг л хотонд байна шүү дээ.

Гэтэл өнөөдрөөс 25 жилийн өмнө 4 хотонд байсан бол өнөөдөр 2 хотонд байж ингэж багассан байж байх жишээний. Гэтэл энийг мэдэж байгаа мэргэжилтэн, газрын дарга, энэ яаманд хаана ч байхгүй. Зүгээр л амаараа малын тоо өссөн юм чинь бэлчээр тэлэгдсэн гэдэг ийм агуулгыг ярьж байх жишээний.

Тэгэхээр аль болохоор энэ хүмүүсийг амьдралд жоохон юм үзүүлж, хүмүүсийн дуу хоолойг Одонтуяа сайдаа сонсгож байхгүй ийм дандаа агаарын юм ярьдаг, дандаа худлаа ярьдаг. Ярьж байгаа юмнуудынх нь тал нь энэ яамныхан худлаа юм ярьдаг ийм хүмүүс байдаг юм байна лээ. Тодруулга ав, жишээлбэл тэр ирвэсийн асуудал дээр аймгийн Засаг дарга байхдаа миний хувьд үнэхээр энэ Говь-Алтай аймаг энэ Алтайн нуруунд ингээд ирвэсийн асуудал хүнд байна, энийг нүүлгэн шилжүүлэх дээр тэр гаднын зоо паркуудад ирвэс өгөх энэ боломжийг энэ боломжийг судлаач. Дараа нь энэ хүний амь нас хохирсон тохиолдолд яах юм бэ, энэ нөхөн олговрын асуудлыг яах вэ гэж хэлээд маш олон бичиг явуулсан. 1 ч хариу ирээгүй. Яаман дээр ирсэн бичиг бол тэгээд л нөгөө элсэнд хаясан зүү шиг ингээд л алга болдог ийм байдаг л даа. Тэгэхээр одоо бол нөгөө бид нарын тэр өргөн барих гэж байгаа хуулиар орон нутаг руу эрх мэдэлд шилжчихвэл орон нутагтаа энэ асуудал маань ингээд аятайхан шийдэгдээд явах ийм боломж бүрдэнэ гэж ингэж харж байгаа.

Б.Бейсен: 1 номер гүйцээж хариулъя.

Ц.Уранчимэг: Ирвэс, ирвэсийн тоо толгой одоогийн яг Олон улсын байгууллага төслийн хүрээнд тоолсон тоо бол мянга гаруй тоо толгой ирвэс байгаа. Олон улсын хэмжээнд нэн ховор ангилалд ордог. Тэгэхээр түрүүн Наранбаатар гишүүн асуусан. 2024-өөс 25 онд 31541 мал саарал чононд барьсан байна, идсэн байна гэдэг ийм тоо судалгааг бид экологийн цагдаагаас авсан байгаа. Тэгэхээр яг энэ нэн ховор, ховор амьтныг яг барихад агнахгүй тодорхой тоо хэмжээг нь зохицуулах ёстой гэдэг нь одоо байгаа Амьтны тухай хууль дээрээ байгаа боловч Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам бол Амьтны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хийгээд явж байгаа. Тэгэхээр гишүүддээ бас яг энэ нарийн зохицуулалтыг оруулах зайлшгүй шаардлагатай байгаа зүйл, заалтыг бодвол Конвенцынхоо хуульд нийцүүлээд бид энийг хийх нь яамны зүгээс бодлогоор дэмжиж байгаа. Энэ ганцхан ирвэс, чоно гэхгүй бусад яг ховор амьтны энэ асуудлууд байгаа. Тэгэхээр энийг.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбат гишүүн тодруулъя.

Ц.Мөнхбат: Тэгээд ирвэст баригдсан тоо байдаггүй юм шиг байна. Ер нь асуудал болгож тавиад байна гэдэг чинь бий болоод байна гэсэн үг л дээ. Малчид нь тухайн тэр Гурвантэсийнхэн бол юу ярьж байгаа юм гэхээр зэрэг өмнө нь тэгдэггүй байсан юм. Одоо олноороо ороод ирж байна гэдэг чинь тоо толгой нэмэгдээд байна гэсэн үг гэж ойлгож байна гэж байгаа юм. Яам болохоор зэрэг тоо толгой өсөөгүй гээд байдаг гэж байгаа юм. Хэдэн жилийн өмнөөс гэлээ бараг арваад жилийн өмнөөс ч билүү саяын та 1400 гаруй гэххэв үү, ийм тоо л байгаад байдаг л юм хариу өгдөг. Гэтэл айлын хот руу олноороо ороод байна гэдэг чинь ихсээд байна гэж бид ойлгож байна гэж нутгийн иргэд нь тэгж байгаа юм. Тэгээд яг энэ чонотой адилхан ирвэст баригдаад байвал бас яах вэ? Энэ дээр та хэд маань ямар арга хэмжээ авах вэ л гэж асуугаад байгаа юм.

Б.Бейсен: 1 номер хариулъя.

Ц.Уранчимэг: Түрүүн би хэлсэн. Амьтны тухай хуульд шинэчилсэн найруулгын төслийн хууль бид боловсруулаад явж байгаа. Энэ дээр бас яах аргагүй ялангуяа нэн ховор, ховор амьтан төрийн өмч гээд бүртгэлтэй байдаг. Тэгэхээр нөхөн төлбөр олгох харилцааг энэ дээр огт зохицуулаагүй байгаа. Амьтны тухай хууль дээр ч, яг экологийн Эрүүгийн хууль дээр ч гэсэн зохицуулсан харилцаа байхгүй учраас малын даатгалын харилцаанд зохицуулах гэдэг заалт зүүлтийг бид судлаад яг тэр хүрээнд нь зохицуулалт хийж олгох, нөхөн төлбөрийн харилцааг оруулах гэдэг асуудлыг явж байгаа. Ирвэс зөвхөн нөгөө тоо толгой нь ихсэх, багасах гэдэг дээр биш ер нь уур амьсгалын өөрчлөлт, зэрлэг амьтны нөгөө агаар бүс нутаг нүүдэл шилжилт хөдөлгөөн өөрчлөгдөж байгаа, идэш тэжээлийн динамик өөрчлөлттэй холбоотой нүүдэл шилжилт хөдөлгөөн нь өөрчлөгдөж байгаа ийм асуудлууд байгаа. Тэгэхээр яг тодорхой судалгаа шинжилгээний үндсэн дээр энэ зохицуулалтыг Амьтны хууль дээр нарийвчлан зааж өгөх үнэхээр хэрэгцээ шаардлага байгаа. 2012 оноос хойш энэ хуульд шинэчилсэн найруулга, нэмэлт.../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан санал хэлэх гишүүн байна уу? Замира гишүүнээр тасаллаа.

С.Замира: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Урьд нь ийм хууль байгаа юм байна. Түүнтэй харьцуулаад зогсохгүйгээр нэг юу гарах нь зүйтэй юм шиг байна. Яагаад гэвэл хүний амь нас эрсдэж байгаа гэнэ. Тэгээд саарал, ганцхан саарал биш ирвэс гээд нэг яриад байгаа шүү дээ. Уг нь хашаа хороонд орж ирж хүний амь насанд халдахаар хэмжээнд байсан нөхцөлд ирвэс нь ч байна уу, саарал нь ч байна уу шууд буудан алах гэсэн нэг заалт оруулж өгвөл яадаг юм бэ? Яагаад гэвэл хүний амь энэ ан амьтнаас үнэтэй биз дээ. Уг нь тийм нэг заалт оруулж өгөөч гээд тийм санал хэлэх гээд байна. Амжилт хүсье, баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд санал хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 86,7 хувиар дэмжигдлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Аубакир гишүүн танилцуулна. 1 дүгээр асуудал дууслаа.

11.22 цаг

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Дараагийн асуудалд оруулъя. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь: Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Жигжидийн Батжаргал Улсын Их Хурлын гишүүн, гишүүдэд Б.Бат-Эрдэнэ гишүүн, Ж.Бат-Эрдэнэ, гишүүн, Ц.Идэрбат гишүүн, Б.Найдалаа гишүүн, Н.Наранбаатар гишүүн, Ц.Мөнхбат гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсгийн ахлагч Жигжидийн Батжаргалд зөвшөөрсүгэй.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Бейсенд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төслөө баталъя. Одоо нэг. 53,3 хувиар дэмжигдлээ. Энэ асуудлыг хэлэлцээд дууслаа. Дараагийн асуудалд оръё. Уянга гишүүний дэмжсэнээр протокол тусгая. Дараагийн асуудал чинь, санал авсан сая. Батчимэг гишүүн орох хүсэлтэй байгаа юм уу?

11.25 цаг

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай/

Дараагийн асуудалд оръё. Энэ ажлын хэсгийн удирдамжийг батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Намрын чуулганы төгсгөлд Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээр ахлуулсан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу Байнгын хорооны тогтоолоор батлахаар заасны дагуу өнөөдөр танилцуулж байна.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Ажлын хэсгийн удирдамжийг батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байна уу? Асуулт асуух гишүүн байхгүй байна. Ажлын хэсгийн удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

11.27 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА